

## ХИЛИЙН ЦЭРГИЙН ХАРУУЛЫН ДАРГЫН АЖЛЫН АЧААЛЛЫН ШИНЖИЛГЭЭ

### Т.НАРАНБААТАР

ДХИС-ийн Удирдлагын академийн магистрант, хошууч

### Я.АРИУНБОЛД

ДХИС-ийн Хилийн албаны удирдлага, стратегийн профессорын багийн профессор, хурандаа

**Товч агуулга:** Хилийн харуул нь улсын хил хамгаалалт, албаны үйл ажиллагааг улсын хил дээр зохион байгуулж бүрэлдэхүүн нь ээлжээр томилогдон үүрэг гүйцэтгэдэг бөгөөд ихэнх тохиолдолд нэг, хилийн харуулд хоёр харуулын дарга ээлжлэн үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь энгийн байгууллагын алба хаагчидтай харьцуулахад хэт их ачаалал бөгөөд хил хамгаалах байгууллагын бусад албан тушаалтантай харьцуулахад ачаалал их байгаа юм. Иймд хилийн харуулын дарга нарын ажлын ачааллыг багасгах нь зүйтэй хэмээн энэхүү өгүүллэг боловсрууллаа.

**Түлхүүр үгс:** Хил хамгаалах байгууллага, хилийн харуул, харуулын дарга, ажлын ачаалал, дүн шинжилгээ.

### Оршил

Монгол Улсын хил хамгаалалтыг зохион байгуулах чиг үүрэг бүхий Хил хамгаалах байгууллагын анхдагч нэгж нь хилийн харуул бөгөөд түүнийг хилийн харуулын дарга удирддаг. Хилийн харуулд хил хамгаалах, сургалт дадлага явуулах, сэтгэлзүй, соёл сурталчилгааны ажил зохион байгуулах, ар тал, зэвсэг, инженерийн зэрэг ажлыг цогц байдлаар уялдуулан өдөр тутам зохион байгуулдаг онцлогтой. Хилийн харуулын дарга бүрэн дунд боловсролтой байх шаардлага тавигддаг бөгөөд хилийн харуулын дарга нь дээд боловсролтойгоо алба хаагчдаас эхлээд огт боловсролгүй хугацаат цэргийн алба хаагчдыг удирддаг хариуцлагатай албан тушаал юм.

Улсын хилийн халдашгүй дархан байдал, улсын хил хамгаалалтын үр дүн нь торгон хилийн шугаман дээр үүрэг гүйцэтгэж буй хилчдээс шууд хамаарна. Өнөөгийн байдлаар хилийн харуулын дарга нь харуул дээр бүх үйл ажиллагааг хариуцан хэт их

ачаалалтай үүрэг хүлээж, удаан хугацаагаар ажиллаж байна. Энэ нь тэдний ажлын бүтээмжид сөргөөр нөлөөлж шинээр сэтгэх бүтээх, ар гэрийн амьдралаа дээшлүүлэх, сурах, мэдлэг боловсролоо ахиулах, албан тушаал дэвших боломжийг хязгаарлаж байна.

Иймд хилийн харуулын даргын ажлын ачааллыг бууруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, харуулын дарга нарын мэдлэг боловсролоо ахиулах, албан тушаал дэвших зэрэг боломжийг бий болгоход оршиж байна.

### Үндсэн хэсэг

**Нэг. Хил хамгаалах байгууллага, хилийн харуулын тухай ойлголт**

Улсын хил хамгаалах байгууллага гэж Монгол Улсын хэмжээнд улсын хил хамгаалалтыг зохион байгуулах, удирдах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, түүний харьяа хилийн цэргийн анги, салбарыг хэлнэ<sup>1</sup>;

**Хил хамгаалах байгууллагын үндсэн үүрэг**

<sup>1</sup> П.Даш Хилийн харуул УБ, 1998 он 9 дэх тал

1.Улсын хил хамгаалалтын талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх;

2.Улсын хил хамгаалалтыг зохион байгуулж удирдах;

3.Монгол улсын олон улсын гэрээ, хэлэлцээрээр хилийн асуудлаар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх;

4.Улсын хилийн шугам, тэмдэг, холбоосын байршлыг хууль бусаар өөрчлөх явдал гаргуулахгүй байх;

5.Улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулж, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх;

6.Хилийн аливаа асуудлыг хууль зүйн дагуу шийдвэрлэх;

7.Улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу шалган нэвтрүүлэх хэмээн хуульчилсан байна.

**Хилийн харуулын үүсэл хөгжил.** Хилийн харуулын үүсэл хөгжил Улсын хил хамгаалалт үүсч бий болсон цагаас буюу манай эрний өмнөх IV зуунаас өнөөг хүртэл уламжлагдан ирсэн хил хамгаалалтын үнэт баялгийн нэг нь хилийн харуул юм. Тэр үеийн хилийн харуулын онцлог болон үйл ажиллагааны талаар тодорхой зүйл одоо хир олдоогүй ч гэсэн хилийн харуул бодитойгоор байжээ гэдгийг доктор Г.Сүхбаатар 1980 онд бичсэн “Монголчуудын эртний өвөг” зохиолдоо баталсан байдаг. Хилийн харуул нь үеийн үед шинэ шинэ агуулгаар баяжиж хувьсан өөрчлөгдсөөр өнөөг хүрчээ. Суман харуул, өрхийн гэр харуул, өртөө харуул, цагдаа харуул, хилийн пост, хилийн харуул гээд төрөл бүрийн нэрээр нэрлэгдэж түүндээ тохирсон үйл ажиллагаа явуулж байв.

**Хилийн харуул.** Улсын хилийн тодорхой хэсгийг байнга хамгаалах, тусгайлан өгөгдсөн үүргийг биелүүлэх зорилгоор зориулалтын

дагуу төхөөрөмжилсөн байранд буюу хөдөлгөөнт журмаар байрлаж өөрөөсөө хилийн манаа томилон үүрэг гүйцэтгүүлж буй нэгжийг хилийн харуул гэнэ

**Хилийн харуулын дарга, түүний үүрэг.** Хилийн харуулын дарга хариуцсан хэсгийн хил хамгаалалт, бие бүрэлдэхүүний албаны бэлэн байдал, сонор сэрэмж, цэргийн сахилга, хүмүүжил, онолын болон эрх зүйн бэлтгэл, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж дараах үүрэг хүлээнэ<sup>1</sup>.

1.Хариуцсан хэсгийн хил хамгаалалтыг отряд, заставын даргаас өгсөн тушаал, хуваарийг үндэслэн зохион байгуулж, удирдах;

2.Бие бүрэлдэхүүний бэлэн байдал, сонор сэрэмжийг байнга дээшлүүлж, үүргээ чадварлаг биелүүлдэг болгон сургах;

3.Хилийн тухай хууль, хил хамгаалалтын дүрэм, бусад хууль тоогтоомж, удирдлагын баримт бичгүүдийг судалж мэдэн, бүрэн биелүүлэх;

4.Хилийн манаанд тушаал өгөх, тушаалын биелэлтэд хяналт тавих, хил хамгаалалтад биечлэн оролцох;

5.Хууль ёс, цэргийн болон албаны дүрмийг чанд сахих;

6.Дадлага сургууль, хүмүүжлийн ажлыг батлагдсан заавар төлөвлөгөөний дагуу явуулж, албаны ажиллагааг дүгнэх;

7.Галын аюулаас урьдчилан сэргийлэх болон аюулгүй арга хэмжээг харуулын бүрэлдэхүүнээр чанд мөрдүүлэх;

8.Хилийн харуулын техник хэрэгсэл, албаны амьтад, эд хогшлийг бүрэн байлгаж, тэдгээрийг зөв ашиглан арчилгаа үйлчилгээг тогтмол хийлгэх;

9.Харуулын бүрэлдэхүүний эрүүл мэнд, сэтгэл зүй, хангалтын

<sup>1</sup> П.Даш. Монгол Улсын хилийг харуулаар хамгаалах ажиллагааг боловсронгуй болгох нь цэргийн шинжлэх ухааны доктор (Ph.D)

зэрэг горилсон бүтээл. Батлан хамгаалах их сургууль, УБ., 2000 он

байдалд байнга анхаарал тавьж тэдгээрийг хил хамгаалалт албаны зохион байгуулалтыг алдагдуулахгүйгээр цаг тухайд нь шийдвэрлэж байх;

10.Хариуцсан хэсгийн торон саад, мөр хянах зурвас, хянах байр, цамхаг бусад инженерийн төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээ бүрэн бүтэн байдлыг хариуцах.

#### **Хилийн харуулын даргын ажлын байрны тодорхойлолт**

Хилийн харуулын дарга хариуцсан хэсгийн хил хамгаалалт, бие бүрэлдэхүүний албаны бэлэн байдал, сонор сэрэмж, цэргийн сахилга, хүмүүжил, онолын болон эрх зүйн бэлтгэл, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцахаас эхлээд хил хамгаалалтын дүрэм, цэргийн дүрэм, хилийн цэргийн хүний нөөцийн дүрмэнд тус тус тодорхой заасан байдаг.

#### **Хоёр. Хилийн харуулын даргын ажлын ачааллын өнөөгийн байдал**

Инхэн хилийн харуулд хоёр харуулын дарга ээлжлэн үүрэг гүйцэтгэдэг бөгөөд дунджаар 10 хоног үүрэг гүйцэтгэдэг энэ нь нэг сарын 20 хоногт нь хилийн харуулд ажиллаж гэр орноосоо хол байдаг. Мөн хилийн заставт 10 хоног ажиллахдаа заставын жижүүр, хилийн манаанд явах зэргээр үүрэг гүйцэтгэдэг.

Хилийн харуулд 10 хоног үүрэг гүйцэтгэтгэх хугацаанд хилийн цагийн байдлын өрнөлтөөс хамаарч

#### **Хүснэгт 2. Албан тушаал, ажил үүргийн хуваарь**

| Үйл ажиллагааны чиглэл  | Хил хамгаалах ерөнхий газар                                                                                                                       | Хилийн отряд                                            | Хилийн застав            | Хилийн харуулд |
|-------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------|--------------------------|----------------|
| Хил хамгаалалт          | -Хилийн цэргийн штаб<br>-Хилийн алба хилийн төлөөлөгчийн газар,<br>-Хил хамгаалалтын хэлтэс<br>-Шуурхай удирдлага, мэдээлэл дүн шинжилгээний алба | -Отрядын дарга<br>-Штабын дарга<br>-Хилийн албаны тасаг | -Заставын дарга          | Харуулын дарга |
| Сургалт, цэргийн албаны | -Сургалтын хэлтэс<br>-Цэргийн алба зохион байгуулалтын хэлтэс                                                                                     | -Сургалт, цэргийн албаны зохион                         | -Сургалт эрхэлсэн орлогч | Харуулын дарга |

5-10 удаа хилийн манаанд үүрэг гүйцэтгэх;

Хилийн харуулын цагийн манааг хоёр цаг тутамд халалцуулж зэвсэг, галт хэрэглэлийг хүлээлгэн өгөх, хүлээн авах;

Хилийн манааны үүрэг гүйцэтгэлт, сонор сэрэмжийг шалган үр дүнг тооцох;

Хилийн застав, хөрш харуул, хилийн манаатай холбоо харилцан ажиллагааг зохион байгуулах, мэдээ мэдээлэл солилцох;

Өдөр бүр хугацаат цэргийн алба хаагчдад хилийн алба, цэргийн дүрэм, биеийн тамирын хичээлээр сургалт дадлага явуулах;

Хугацаат цэргийн алба хаагчдад соёл олон нийтийн ажил, уралдаан тэмцээн зохиох, мэдээлэл, ухуулга яриа хийх, ганцаарчлан уулзах, сэтгэл санааг судлах;

Албаны бичиг баримтыг хөтлөж баримтжуулах;

Зэвсэг галт хэрэгсэл, инженерийн торон саад, мөр хянах зурвасын бүрэн бүтэн байдлыг хариуцах;

ХЦАХ-ын эрүүл мэнд, ариун цэврийн байдалд хяналт тавих;

Ар талын ажил болох байр орон, галалгаа, хоол хүнс, хувцас, агт уналга, зэргийг зохион байгуулдаг.

Хилийн харуулын даргын гүйцэтгэдэг дээрх үүргийг Хил хамгаалах ерөнхий газар, хилийн отряд, хилийн заставт тус бүр доорх газар, хэлтэс, алба, тасаг, албан тушаалтан хариуцан ажилладаг.

| зохион байгуулалт             |                                                                                                                                                                                                                                                                            | байгуулалтын тасаг                                                                                                                                      |                                                |                |
|-------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------|----------------|
| Холбоо, харилцан ажиллагаа    | -Холбоо, мэдээллийн хэлтэс                                                                                                                                                                                                                                                 | -Холбоо, мэдээллийн алба                                                                                                                                | -Ахлах холбоочин                               | Харуулын дарга |
| Сэтгэл зүй, соёл сурталчилгаа | -Сэтгэл зүй, соёл сурталчилгаа хэлтэс                                                                                                                                                                                                                                      | -Сэтгэл зүй, соёл сурталчилгаа алба                                                                                                                     | -Сэтгэл зүй, соёл сурталчилгаа эрхэлсэн орлогч | Харуулын дарга |
| Ар тал                        | -Ар тал, зэвсэг тенхикийн газар<br>-Ар тал, зэвсэг тенхикийн хэлтэс<br>-Хангалт үйлчилгээний алба<br>-Барилга захиалагчийн алба<br>-Хүнсний хангалт хариуцсан офицер<br>-Хувцасны хангалт хариуцсан офицер<br>-Хүн эмнэлгийн алба<br>-Мал аж ахуй хангалт хариуцсан офицер | -Ар тал хангалтын дарга<br>-Техникийн алба<br>-Барилга орон сууцны алба<br>-Хүнсний алба<br>-Хувцасны алба<br>-Хүн эмнэлгийн алба<br>-Мал аж ахуйн алба | -Жагсаалын дарга                               | Харуулын дарга |

Эх сурвалж: Хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн дүрэм. УБ., 2019 он.

Дээрх судалгаанаас үзэхэд хилийн харуулын дарга нь дунджаар жилийн 30 хоног ээлжийн амралттай, 165 хоног хилийн харуулд, 80 хоног хилийн манаа, заставын жижүүрийн үүрэг гүйцэтгэлттэй, 85 хоногт хилийн манаа, жижүүрийн амралт, хичээл сургалт, уралдаан тэмцээн бусад ажилтай байна.

Энэ нь тус харуулын дарга жилийн 245 хоног гэр бүлээлээсээ тэр дундаа цэцэрлэг, сургуулийн насны хүүхдүүдээсээ 305 хоног тусдаа байна гэсэн үг юм.

Нийт хилийн харуулын дарга нарын 43.2 хувь нь тухайн сумын, 35.7 хувь нь тухайн аймгийн, 21.1 хувь нь Улаанбаатар хот болон бусад аймгаас ажиллаж байна. Ахлагчийн албанд ажиллаж байгаа албан тушаалтнуудын доод шатны албан тушаал нь хилийн харуулын дарга бөгөөд ажилдаа алдаа дутагдал гаргасан ахлагч нарыг хилийн харуулын даргаар томилдог жишиг тогтоод байна. Харин сайн ажилласан харуулын дарга нь ахих дэвших боломж хомс бөгөөд дээд боловсрол эзэмшиж байж дараагийн албан тушаалд дэвших боломж нээгдэнэ.

## Дүгнэлт

Хилийн харуулын дарга нарын үүрэг гүйцэтгэлт, ажлын ачаалал их байгаагаас хийж буй ажлаа бүрэн төгс хийдэггүй, зөвхөн өгөгдсөн үүргийг л биелүүлж байгаа нь алба үйл ажиллагаа доголдох, цаашлаад алдаа дутагдал гарах үндэслэл болдог. Харуулын дарга нарын боловсролын түвшин бага, мэргэшүүлэх болон бусад сургалтад төдийлөн хамрагддаггүйгээс удирдан зохион байгуулах чадвар муу зөвхөн өөрийн туршлагаар ажиллаж байна.

Тэд ажиллах ихэнх хугацааг хилд үүрэг гүйцэтгэж байгаа нь ар гэрийн байдлаа дээшлүүлэх, хүүхдийн сурлага хүмүүжлийн байдалд ч сөргөөр нөлөөлж байгаа тул санхүүгийн байдлыг дэмжих, гэр орон, үр хүүхэддээ зарцуулах боломжийг нэмэгдүүлэх, цэргийн жинхэнэ тэтгэвэрт богино хугацаанд гаргах нь зайлшгүй анхаарах асуудал юм.

## Санал

- Хилийн харуулын дарга нарын тоог нэмж нэг хилийн харуулын даргыг сард нэг удаа хилийн харуулд томилон үүрэг гүйцэтгүүлэх;

- Тэднийг дээд боловсролтой болгох, мэргэшсэн харуулын даргын сургалтад хамруулж бэлтгэх зэрэг болно.

**Эх сурвалжийн жагсаалт**

- Хилийн тухай хууль. Төрийн мэдээлэл. 2016 он. №6

- Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль. Төрийн мэдээлэл. 2016 он. №36

- Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого. Улсын их

хурлын 2002 оны 20 дугаар тогтоолын хавсралт

- П.Даш. Монгол Улсын хилийг харуулаар хамгаалах ажиллагааг боловсронгуй болгох нь. Цэргийн шинжлэх ухааны доктор (Ph.D) зэрэг горилсон бүтээл. Батлан хамгаалах их сургууль, УБ., 2000 он

- Хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн дүрэм. УБ., 2019 он.

- П.Даш. “Хилийн харуулын дарга” УБ. 1998 он